БАТЛАВ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНХУЯГ

2026 оны .. дугаар сарын .. -ны өдөр

# БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 2026 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Шаардлагатай төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2025/ | Зорилтот түвшин /хэрэгжих дуусах хугацаа/ | Хугацаа | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| НЭГ. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ | | | | | | | |
| 1.1 | Яамны харьяа байгууллагууд Авлигын эсрэг хууль тогтоомжийг жилд 1 удаа алба хаагчдад сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Зохион байгуулсан сургалтын тоо | Яам, харьяа байгууллагын хэмжээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийг 6 удаа зохион байгуулсан. | *Хагас жилийн байдлаар:* Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалт зохион байгуулах хуваарийг батлуулж, харьяа байгууллагуудад хүргүүлсэн байна. Харьяа 7 байгууллага батлагдсан хуваарийн дагуу Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалт зохион байгуулсан байна. *Жилийн эцсийн байдлаар:* Яамны харьяа 8 байгууллагын алба | I-IV улирал | Яам, харьяа байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагчдад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байна. | | |
| 1.2 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, алба хаагчдад авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх 1-110 дугаар, яамны 1800-1144 дугаар зэргийг сурталчлах | Үйл ажиллагааны зардлаар | Сурталчилгаа хийсэн тоо, хандалтын хувь | Авлигын эсрэг 2 контент, байгууллага тус бүр 1 постер хийж алба хаагчдад хүргэсэн. | *Хагас жилийн байдлаар:* Харьяа байгууллага бүр байгууллагын цахим хуудсаараа дамжуулан авлигын эсрэг 1 постер хийж сурталчилгаа явуулсан байна. *Жилийн эцсийн байдлаар:* Харьяа байгууллага бүр байгууллагын цахим хуудсаараа дамжуулан авлигын эсрэг 1 контент, рийл хийж сурталчилгаа явуулсан байна. Салбарын алба хаагчдын 90-ээс доошгүй хувьд сурталчилгааг түгээсэн байна. | I-IV улирал | Яам, харьяа байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд |
| 1.3 | Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх (видео бичлэг, контент, рийл) сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Видео бичлэг, контент, рийл зэргийн хандалтын хувь | Авлигын эсрэг 2 контент, 2 постер бүтээж олон нийтэд хүргэсэн. | *Хагас жилийн байдлаар:* 1 контент, 1 постер хийж БХЯ-ны болон Соёмбо редакцын цахим хаягаар сурталчилсан байна. *Жилийн эцсийн байдлаар:* 2 контент, 2 постер хийж БХЯ-ны болон Соёмбо | I-IV улирал | Соёмбо редакц |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | редакцын цахим хаягаар сурталчилсан байна. Салбарын алба хаагчдын 90-ээс доошгүй хувьд сурталчилгааг түгээсэн байна. | | |
| 1.4 | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контент, рийл, постер зэргийг цахим хуудас, байгууллагын дотоод сүлжээ, сурталчилгааны самбар болон бусад хэлбэрээр сурталчлах | Үйл ажиллагааны зардлаар | Цахим хуудасны хандалтын хувь болон бусад сурталчилсан тоо | Байгууллагууд цахим хуудсаар болон байгууллагын сурталчилгааны самбар зэргээр олон нийтэд хүргэж байсан. | *Хагас жилийн байдлаар:* АТГ-аас бэлтгэсэн контент болон бусад хэлбэрийн сурталчилгааны ажлыг байгууллага бүр 4 удаа зохион байгуулсан байна. *Жилийн эцсийн байдлаар:* АТГ-аас бэлтгэсэн контент болон бусад хэлбэрийн сурталчилгааны ажлыг байгууллага бүр 8 удаа зохион байгуулсан байна. Сурталчилсан талаарх нотлох баримт, тоо, хандалтын хувийг хагас, бүтэн жилээр гаргасан байна. | I-IV улирал | Яамны харьяа байгууллагууд |
| 1.5 | Батлан хамгаалах яамны удирдах бүрэлдэхүүн (хэлтсийн даргаас дээш), яамны харьяа байгууллагын дарга нарт Авлига, | 1,0 сая төгрөг Яамны сургалтын зардлаас | Сургалтад хамруулсан удирдах бүрэлдэхүүний тоо | 2024 онд БХЯ, ЗХЖШ-ын удирдах бүрэлдэхүүнийг хамруулсан сургалтыг 1 удаа зохион байгуулсан. | *Хагас жил, жилийн эцсийн байдлаар:* Яам, харьяа байгууллагын удирдах бүрэлдэхүүнийг 1 удаа | I улирал | Яамны эрх бүхий албан тушаалтан |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаарх сургалтыг зохион байгуулах | | | | сургалтад хамруулсан байна. | | |
| 1.6 | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах цахим болон танхимын сургалтад алба хаагчдыг хамруулах | Үйл ажиллагааны зардлаар | Сургалтад хамруулсан алба хаагчдын тоо | 2025 онд цахим сургалтад 39 алба хаагч, сургагч багшийн дамжаанд 2 алба хаагч хамрагдсан. | *Хагас жил, жилийн эцсийн байдлаар:* АТГ-аас зохион байгуулсан сургалтад алба хаагчдыг тухай бүрд нь бүрэн хамруулсан байна. | I-IV улиралд | Яам, харьяа байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд |
| 1.7 | “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж байгаа залууст Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар сургалт зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Сургалтад хамруулсан алба хаагчдын тоо | “Оюутан цэрэг”-т хамрагдаж байгаа залууст Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар сургалт зохион байгуулаагүй. | *Хагас жил, жилийн эцсийн байдлаар:* Улаанбаатар цэргийн хүрээнд Оюутан цэрэгт хамрагдах 1000 алба хаагчдад сургалт зохион байгуулсан байна. | III улирал | Яамны ОНХДГ, яамны эрх бүхий албан тушаалтан |
| 1.8 | АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран яам, харьяа байгууллагын алба хаагчдад Авлигын эсрэг сургалтын зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Сургалт зохион байгуулсан тоо, хамралтын хувь | Яам, харьяа байгууллагын нийт 280 гаруй алба хаагчдад сургалт зохион байгуулсан. | *Хагас жилийн байдлаар:* Яамны харьяа 5 байгууллагын алба хаагчдыг хамруулсан сургалтыг 1 удаа зохион байгуулсан байна. *Жилийн эцсийн байдлаар:* Яамны харьяа 10 байгууллагын алба хаагчдыг хамруулсан сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна. | I-IV улирал | АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтарч |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сургалт зохион байгуулсан нотлох баримт, тоо, хандалтын хувийг хагас, бүтэн жилээр гаргасан байна. | | |
| 1.9 | Батлан хамгаалах салбарын хэмжээнд гадаадын зээл тусламж болон төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд хариуцсан нэгжтэй уулзалт зохион байгуулах, зөвлөмж, туслалцаа үзүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Уулзалт зохион байгуулсан тоо | 2025 онд БХЯ, ЗХЖШ-ын төсөл хөтөлбөр, зээл тусламж, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бүрэлдэхүүнтэй 1 удаа уулзалт зохион байгуулсан. | *Хагас жилийн байдлаар:* ҮБХИС-ийн төсөл хөтөлбөр, зээл тусламж, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бүрэлдэхүүнтэй 1 удаа уулзалт зохион байгуулсан байна. *Жилийн эцсийн байдлаар:* Батлан хамгаалахын аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ, Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын төсөл хөтөлбөр, зээл тусламж, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бүрэлдэхүүнтэй 1 удаа уулзалт зохион байгуулсан байна. | I, III улирал | АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтарч |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.10 | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулах бүх төрлийн гэрээнд хяналт тавих, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар заалтыг тусгаж ажиллах | Үйл ажиллагааны зардлаар | Иргэд, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний тоо | Батлан хамгаалах яам 2025 онд нийт 44 арга хэмжээний 174 багц тендерт шалгарсан байгууллагуудтай 216 гэрээ байгуулан ажилласан. | *Хагас жилийн байдлаар:* Яам, харьяа байгууллагаас зарласан тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй байгуулах бүх төрлийн гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тусгагдсан байна. *Жилийн эцсийн байдлаар:* Яам, харьяа байгууллагаас зарласан тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй байгуулах бүх төрлийн гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тусгагдсан байна. Гэрээ байгуулсан, гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тусгагдсан нотлох баримт, тоог яамны ЭБАТ-д хагас, бүтэн жилээр ирүүлсэн байна. | I, III улирал | Яамны БХЗГ, тендер шалгаруулалт зохион байгуулж, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан харьяа байгууллагууд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| ХОЁР. АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ | | | | | | | |
| 2.1 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Олон нийттэй харилцах төвийн 11-11 тусгай дугаар, Батлан хамгаалах яамны тусгай дугаар "1800-1144", 11458929 дугаарт иргэд, төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх | Үйл ажиллагааны зардлаар | Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн тоо | ОНХТ-ийн 11-11 тусгай дугаарт 74, яамны 1800-1144 тусгай дугаарт 240, 11458929 дугаарт 120, нийт 434 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирүүлснийг шийдвэрлэж ажилласан байна. | *Хагас жилийн байдлаар:* Яам, харьяа байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна. *Жилийн эцсийн байдлаар:* Яам, харьяа байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаарх нотлох баримт, тоог хагас, бүтэн жилээр гаргаж яамны ЭБАТ-д ирүүлсэн байна. | I-IV улирал | Яамны өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн болон харьяа байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан тушаалтан |
| 2.2 | Яам, харьяа байгууллагууд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | Үйл ажиллагааны зардлаар | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шилэн дансанд оруулсан мэдээллийн тоо | Яам, харьяа байгууллагууд шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээллийг оруулж хэвшсэн. | *Хагас жилийн байдлаар:* Яам, харьяа байгууллагаас шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээллийг оруулсан байна. *Жилийн эцсийн байдлаар:* Яам, харьяа байгууллагаас шилэн дансанд хуулийн | I-IV улирал | Яамны ХШҮДАГ, СХОГ, яамны харьяа байгууллагын холбогдох албан тушаалтнууд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацаанд мэдээллийг оруулсан байна.<br>Шилэн дансанд оруулсан мэдээллийн талаарх нотлох баримт, тоог хагас, бүтэн жилээр гаргаж яамны ЭБАТ-д ирүүлсэн байна. | | |
| ГУРАВ. АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ | | | | | | | |
| 3.1 | Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах, үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох судалгаа авах, дүгнэлт гаргах | Тандалт, судалгаанд шаардагдах бичиг хэргийн материалын зардлаар | Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо | Яам, харьяа байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдээс судалгаа авч байгаагүй. | *Хагас жил, жилийн эцсийн байдлаар:*<br>Байгууллага бүр үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох судалгааг авч, дүгнэлт гаргасан байна.<br>Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоог хагас, бүтэн жилээр нэгтгэн, дүгнэлт гаргаж, яамны жилийн эцсийн тайланд тусгасан байна. | II, IV улирал | БХЕШ-ийн Ажлын алба, ХШҮДАГ, яамны Эрх бүхий албан тушаалтан, харьяа байгууллагын холбогдох албан тушаалтнууд |

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА М.БАТХУЯГ

ТӨЛӨВЛӨСӨН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ,
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
ДЭД ХУРАНДАА Х.МӨНХЗАЯА